



## Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн тухай



“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид болон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчид 1982 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг батлан хэрэгжүүлсээр ирсэн. Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс /хуучин нэршил/ Бүгд Найрамдах Улс болон өөрчлөгдсөнөөр хэлэлцээрийн үйлчлэл Оросын Холбооны Улсад шилжсэн тул тухайн үед Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан улсуудын иргэдийн нийгмийн хамгааллын харилцааг энэ хэлэлцээрээр цаашид зохицуулах боломжгүй болсон. Иймд хэлэлцээр зөвхөн Оросын Холбооны Улсын иргэдийн нийгмийн даатгалын харилцааг зохицуулах болсон.

### А. Хэлэлцээрийн гол агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Оросын Холбооны Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцож байж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган зөвхөн ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Оросын Холбооны Улсад тэтгэвэр тогтоолгох бол Оросын Холбооны Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана. Харин Монгол-Оросын хамтарсан үйлдвэрт ажиллаж байгаа Оросын Холбооны Улсын иргэд Оросын Холбооны Улсын Тэтгэврийн санд, Монгол Улсын иргэд нь Монгол Улсын Нийгмийн даатгалд шимтгэлээ төлнө. Жишээ нь “Эрдэнэт Үйлдвэр”, “Монголросцветмет” гэх мэт байгууллагууд

**Жишээ нь:** Монгол Улсын Иргэн “Г” Монгол Улсын нийгмийн даатгалд 15 жил шимтгэл төлсөн, Оросын Холбооны Улсад 20 жил ажиллаж, амьдрахдаа Оросын Холбооны Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэж үзье.

**Хэлэлцээр хэрэгжээгүй цаг үед:** Иргэн “Г” нь Монгол Улсын хуулийн дагуу 60 буюу тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ч өндөр насны тэтгэвэр авахад шимтгэл төлсөн байвал зохих хугацааны доод хязгаар 20 жилийг хангаагүй учир 15 жилдээ ногдох бүрэн бус хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Хэрэв “Г”-ийн Монгол Улсад шимтгэл төлсөн хугацаа 10 жилээс доош байвал нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхгүй.

**Хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр:** Иргэн “Г” нь Оросын Холбооны Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 35 болгон тооцуулж бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Оросын Холбооны Улсад тэтгэвэр тогтоолгох бол Оросын Холбооны Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

1/Иргэн “Г” нь тэтгэврийн нас болон шимтгэл төлсөн хугацааны аль алины хувьд Монгол Улсын хуульд заасан шаардлагыг хангаж буй учир өргөдлөө гаргаж Монгол Улсад өндөр насны тэтгэврээ тогтоолгоно.

2/ Оросын Холбооны Улсын шинэ хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас нь үе шаттайгаар нэмэгдэж байгаа ч тухайн үед “Г” нь тэтгэврийн нас болон хоёр улсад шимтгэл төлсөн нийт хугацааны аль алины хувьд Оросын Холбооны Улсын хуульд заасан шаардлагыг хангаж байвал өргөдлөө гаргаж Оросын Холбооны Улсад өндөр насны тэтгэврээ тогтоолгоно.

### Б. Ямар төрлийн тэтгэвэр энэ хэлэлцээрт хамаарах вэ?

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Монгол Улс болон Оросын Холбооны Улсын тухайд:

Энэхүү хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч талуудын хууль тогтоомжоор иргэдэд үзүүлж байгаа буюу үзүүлэх нийгэм хангамжийн /өвчлөх, жирэмслэх ба амаржих, өндөр нас, тахир дутуу болох мөн тэжээгчээ алдах буюу бусад тохиолдолд үзүүлж байгаа/ бүхий л төрлийг хамаарна.

## Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Монголын талын харилцагч байгууллагын мэдээлэл

1. Байгууллагын нэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Г.Ганчимэг /ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: ganchimeg.g@mlsp.gov.mn, 51-262686

Б.Ундрэм /ХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: undram@mlsp.gov.mn, 51-264624

2. Харилцагч байгууллагын нэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар  
Т.Уянга /НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын Олон Улсын хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: uyanga.t@ndaatgal.mn, 11-328030 /517/